



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 71

Номгон

“Баянхонгорчуудын бахархалт  
өдөр”-ийг тогтоох тухай

Монгол Улсын Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэд, байгууллага, салбаруудын ололт амжилтыг олон нийтэд мэдээлж сурталчилах, түгээн дэлгэрүүлэх, харилцан туршлага солилцох, иргэдэд үйлчилгээ үзүүлж тэдний санал, хүсэлтийг сонсож, бүтээлч ажил, үйл ажиллагаанд оролцуулах, ажилтан, ажилчдын хөдөлмөр, бүтээлийг тодруулан алдаршуулах зорилгоор “Баянхонгорчуудын бахархалт өдөр”-ийг жил бүрийн аймгийн баяр наадмын өмнөх өдөр тэмдэглэж байхаар тогтоосугай.

2. Бахархалт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журмыг 2017 оны 07 дугаар сарын 15-ны дотор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд хэлэлцүүлэн батлуулж, арга хэмжээний төлөвлөгөө, төсвийг боловсруулж зохион байгуулалтын өндөр түвшинд тэмдэглэн өнгөрүүлж байхыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

0117013